



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	24,391.1	24,391.1
Бараа материал	81,637.2	90,603.1	8,965.9
Үндсэн хөрөнгө	1,496,562.4	2,064,374.6	567,812.2
Нийт хөрөнгө	1,578,212.2	2,179,368.8	601,156.6
Өр төлбөр	0.0	4,005.3	4,005.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,578,212.2	2,175,363.5	597,151.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,578,212.2	2,179,368.8	601,156.6

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,500.0 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өөрийн өртгөө нөхөж 0 үлдэгдэлтэй болсон 124 төрлийн хөрөнгө байна. Мөн 2 объектын газар нь бичиг баримтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалттай тус тус нийцээгүй бөгөөд “иж бүрэн байх” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж бүртгэлийг цэгцлэх, бичиг баримтыг иж бүрэн бүрдүүлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн зарцуулалт	1	3,500.0					1	3,500.0				
Дүн	1	3,500.0					1	3,500.0				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024 02 23 № 01/87

танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЭНХТҮВШИН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 567,812.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газар нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ өөрийн өртгөө нөхөж үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийг дахин үнэлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын дарга нь 2 хөтөлбөр, 7 арга хэмжээний хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Арбулаг сумын Засаг даргаар батлуулж, түүнийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР